

Монголчуудын зарга тэмцлийг зүйр цэцэн үгсээр
мөшгин үзсэн нь
(Түүхийн социологийн судалгаа)

Ч. Тамир*
Р. Төрдалай*

Сүүлийн 5 жилийн хугацаанд бид зарга тэмцлийг түүхийн социологийн үүднээс нарийвчлан судалж байгаа юм¹. Хамгийн сүүлд МУИС-ийн Монгол Судлалын Төвийн *Acta Mongolica* сэтгүүлийн 2005 оны дугаарт хэвлэгдсэн өгүүлэлд өдгөө Үндэсний Төв Архивт хадгалагдаж буй XVIII-XX эхэн үед холбогдох буюу Манж Чин улсын ноёрхлын үеэс Богд хаант Монгол Улсыг хүртэлх Халхын Дөрвөн аймгийн заргын бичгийг судлах тусгайлсан судалгааны арга зүй, аргачлалын зарим саналаа бид та бүхэнд өргөн толилуулсан билээ.² Монголчуудын нийгэм, түүхийн судалгаанд үлэмж ач холбогдол бүхий энэхүү өвөрмөц бичгийн дурсгалыг судлахын сацуу тухайн үеийн монголчуудын зарга тэмцлийн тухай уламжлалт ойлголт, сэтгэлгээг мөшгин тодруулах шаардлага судалгааны явцад бий болсон. Үүний тул өгүүлэн байгаа үеийн талаар олон талын сонирхолтой түүхэн мэдээг бидэнд өгч чадах зүйр, цэцэн үгийг судалгааны объект болгон сонгон авлаа.

Амнаас ам дамжин хэлцэгдэж ирсэн ардын зүйр цэцэн үгсийн арвин баялаг санд зарга тэмцэлтэй холбоотой үгс цөөнгүй бий.³ Тиймээс ч өвөг дээдэс маань “Зүйргүй үг байдаггүй, Зүүдэлгүй дээл байдаггүй” хэмээсэн сургаал бий. Түүхийн урт хугацааны турш эзэн зохиогч тодорхойгүй ч монгол үндэстний оршихуйн үнэлэмж, үнэт зүйлсийг илэрхийлдэг эх сурвалж зүйр, цэцэн үгийг шүүрдэн үзвэл боловч цаг үеийнхээ

* МУИС. НШУС. Социологийн тэнхим, E-mail: ta_miraa@yahoo.com

* ШУА. Олон Улс Судлалын Хүрээлэн, E-mail: suldet@num.edu.mn

¹ Ч.Тамир “Ардын зарга нь улс төрийн оролцооны нэгэн хэлбэр мөн”//Түүх 1 2. МУИС-ийн ЭШСэтгүүл 2003., Ч.Тамир. “Ардын заргыг судлах арга зүйн асуудалд” //Залуу Монголч эрдэмтдийн зуны сургууль ОУЭШХ 2005-2

² Ч. Тамир, Р. Төрдалай, “Монгол заргын бичиг: Судалгааны арга зүй, аргачлалын асуудал”, МУИС. Монгол Судлалын Төв, *Acta Mongolica* (Dedicated to the 100th Birthday of professor Yöngsiyebü Byambuin Rinchen (1905-1977)), Улаанбаатар, 5(2005), 235-240-р тал.

³ Монгол зүйр цэцэн үгийн гурван мянган дээж, Эмхэтгэн найруулсан Д. Заяабаатар, Хянан засварласан Ш. Чоймаа, Улаанбаатар, 1999, 175 тал..

нийгмийн сэтгэлгээг тусгаж энгийн ардаас ихэс дээдэс хүртэл тэрхүү оюуны үнэт өвийг үеэс үе улируулан хууль, дүрэм мэт санаж ахуйдаа мөрдсөөр иржээ. Тиймээс зарга тэмцлийн талаарх монголчуудын уламжлалт сэтгэлгээг зүйр сэцэн, үгсээс гадна цаашид монголчуудын бэлэгдэл зүй, төрийг дээдлэх үзэлтэй хавсруулан судлах шаардлагатай. Эхний шатанд бид судалгаанд шууд болон дам холбогдох зүйр үгсийн жагсаалтыг гаргасан. Дараа нь зүйр цэцэн үгийг утгаар нь тодорхой хэдэн зүйл болгон ангилсан. Ингэхдээ иргэдийн төртэй буюу ноёнттой хийсэн зарга илүүтэй анхаарлын төвд байсан гэдгийг тэмдэглэвэл зохино.

1. Монгол хүний менталитет нь зарга хийхээс аль болох зайлсхийдэг байжээ.

Эртнээс янагш монгол хүний менталитет нь төлөв төвшин, ноён нуруутай, хээгүй, цэвэр ичимтгий, томоотой хүний дүр зураг байжээ. Тиймээс заргыг заяат хүнтэй эсрэгцүүлэн “*Заяат хүн заргагүй, Ерөөлт хүн хэрүүлгүй*” гэж хэлэлцэх нь бий. Ингэж зарга, хэрүүл цухлаас хол явах хэмээсэн монголчуудын уламжлалт сэтгэлгээ, сурган хүмүүнжүүлэх ухаан, бурханы шашны сургаалтай холбоотойгоос гадна төрийн шүтлэгээр тайлбарлаж болно. Профессор С. Дулам энэ тухай *Монгол төрийн цагаан, хар туг-сүлдийн тахилга, бэлгэдэл* хэмээх өгүүлэлдээ бичихдээ: “... Зарга заальхайд унаж амин хэрэгт чирэгдсэн хүн гурван жил тайлгад орж болохгүй⁴” байсан тухай Бүрэнтөгсийн тэмдэглэснийг баталж “Энэ бүх зан заншил нь өдгөө хүртэл Бурхан Халдуныг тахихад Халх Монголчуудын баримталж ирсэн ёс заншилтай яг ижилхэн байгаа юм.” гэж бичжээ.⁵ Иймээс ч жирийн ардууд зарга тэмцэл хийж, хэл ам болохыг аль болох хүсдэггүй, яль шальгүй асуудал хэмээн хэл ам таталж, зарга заальхай үүсгэж явдаг хүмүүст монголчууд таатай хандаж байгаагүй. Иймээс заргалдан тэмцэх нь тухайн үеийн хүмүүсийн амьдралд аргагүйдсэн нөхцөл байдалд хийгдэх сонголт бөгөөд нэг жишээ авч үзье.

“... Эзний иргэн ардыг өмөөрсөн би буруу болох миний мөн болов уу. Би хэдийгээр зангийн тушаалаас байвч, мөнхүү сумын нэгэн ард тул энэчлэн алба хийсээр байвал олон иргэн ард тэсэхгүй нь магад. Бас ч гомдол олон боловч нурууг гаргаж айлтгав. Гуйх нь миний гомдол бусад олон иргэн ардын гомдол боловч айх нь их болоод гаргаж айлтгахгүй өчүүхэн мунхаг би биедээ хүрэхэд толгойгоо барьж айлтганам.”⁶ (Тэнгэрийн тэтгэсний 53-р /1788/ онд Түшээт хан аймгийн бэйс Дэчиняринпилийн хошууны занги Ашигаас Чуулган даргад өргөсөн бичигт)

⁴ *mongyol jang üyil-yin nebterkei toli*, oyun-u boti, бүрintegүс үоollun nayirayulba, ulayanqada, 1999, 1051-1052 tal-a.

⁵ С.Дулам. “Монгол төрийн цагаан, хар туг-сүлдийн тахилга, бэлгэдэл”, Чингис хаан хийгээд түүний өв. Монголчуудын Дэлхийн Их гүрэн (Cingis Chaan und Sein Erbe. Das Weltreich der Mongolen), ХБНГУ-ын Урлаг, Үзэсгэлэнгийн Их танхимд гаргасан “Чингис хаан хийгээд түүний өв – Монголчуудын дэлхийн их гүрэн”, Бонн, 2005.06.16-09.25 үзэсгэлэнд зориулж DAAD болон DFG-ээс зохион байгуулж хийлгэсэн Бага хурлуудын материал, Эрхлэн гаргасан Удо Б. Баркманн, МУИС, Монгол судлалын төв, Улаанбаатар, 2007, 127-128-р тал.

⁶ *Ардын заргын бичиг /XVIII-XX зууны эхэн/,* Эмхэтгэж хэвлүүлсэн Ш. Нацагдорж, Ц. Насанбалжир, Хянан засварласан Д. Гонгор, Улаанбаатар, Шинжлэх Ухааны Академийн Хэвлэх Үйлдвэр, 1966, 12-р тал.

гэжээ. Занги Ашигийн заргатай төстэй энэ мэт тэмцэл нь цаашид Манжийн төрөөс Монголын нийгмийг эрхшээлдээ удаан барихад бэрхшээл учирч болзошгүйг харгалзан Халхын Дөрвөн хан, ихэс ноёдын албат ардыг дураар шахамдуулж захирах явдлыг хязгаарлахад чиглэсэн бодлогыг 1783 оны зарлигаар тогтооход хүрсэн байдаг. Энэ бодлогын тухай Японы судлаач Накамүра Ацүши Хятадын архивт байгаа Монголын талаар Манжийн төрөөс явуулсан бодлогод холбогдох эх сурвалжуудыг судлан үзсэний эцэст дүгнэхдээ:

“Ашигийн зарга бол зөвхөн нэг хошууны хэрэг тул тухайн үеийн олон албат ард цөм өөрийгөө хааны албат хэмээн тооцдог болсон гэдгийг нотлоход хэцүү. Харин дээр дурьдсан 1783 оны хэдэн бодлого бол засаг ноёдын эрхшээлийг шууд хязгаарлах агуулга байх тул эл бодлогыг нийгмийн өөрчлөлтийн эхлэл гэж үнэлбээс зохих мэт.”⁷

гэжээ. Заргалдан тэмцэх үйл явц нь монголчуудад бүлгийн хувьд нэн түгээмэл байсан үйл явц боловч тухайн зарга бичигт эрх ашиг нь хөндөгдсөн тодорхой бүлгийн шинжтэй асуудал л байнга гарч байдаг учраас зарга хийж үзээгүй, заргалдах тухай ойлголтоор хомс дийлэнх хөндлөнгийн хүмүүсийн хувьд зарга тэмцлийн тухай үнэлэмж харьцангуй өөр байгааг дээрх үгнүүдээс харж болох юм. Гэхдээ төртэй буюу ноёнтон заргалдахыг тойруу, дам байдлаар дэмжих явдал нэлээд байсныг тэмдэглэх хэрэгтэй.

2. Зарга тэмцэл нь иргэдийн оролцооны үндсэн хэлбэр мөн.

Дээр өгүүлсэнчлэн тухайн үеийн жирийн ардуудын зүгээс зарга тэмцэл хийх сонирхол бага байсан нь тодорхой байгаа бөгөөд заргалдах үйл явц нь тэдгээр иргэдийн хувьд арга барсан эцсийн сонголт байсан гэлтэй. Энэ үед монголчуудын эзэн харъяатын ёсыг үе улирч сахих уламжлал хүчтэй хэвээр байсан тул элдэв байдлаар ноёдтой мөчөөрхөн шөргөөцөлдөхөөс аль болох зайлсхийдэг байсан билээ. Энэ нь монголчуудын уламжлалт сэтгэлгээтэй ихээхэн уялдаатай хэрэг мөн болно. Үүнийг нэг талаас ихэс дээдэстэй зарга тэмцэл хийхэд жирийн ардууд заргаа авах тохиолдол тун бага магадлалтай, нөгөө талаас уламжлалт төрөө шүтэх сэтгэлгээтэй холбоотой. Гэвч үүнийг сөрж “Ноёноос айвал зарга бүү хий, Нохойноос айвал бадарчин бүү бол” гэх мэт олон үгсийг хэлж ирсэн. Энэ нь зайлшгүй шаардлагатай тохиолдолд зарга хийж эрхээ хамгаалах иргэдийн үйл ажиллагааг үзэл санааны хувьд зөвтгөж байжээ. Бид Үндэсний Төв Архив дахь Халхын Дөрвөн аймгийн он цагийн холбогдлын хувьд өөр өөр үеийн 50 заргын бичгийг түүвэрлэн сонгож судалгаа хийж үзэхэд заргад оролцогчдын тоон үзүүлэлт доорх байдалтай гарч байна.

⁷ Накамүра Ацүши., “Тэнгэрийн тэтгэсний 48-р оны зарлиг ба Монголын нийгмийн өөрчлөлт”, 1911 оны Монголын үндэсний хувьсгалын урьдчилсан нөхцөл ба олон улсын байдал эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл, Эмхтгэсэн Ока Хироки, О. Батсайхан, Токио, 2006, 32-р тал.

Үндэсний Төв Архивт хийсэн судалгааны дүнгээс⁸

		Шкал	Тоо	Хувь /%/
1	Зарга мэдүүлсэн хүний тоо	1 хүн	8	16%
		2-4 хүн	16	32%
		5-9 хүн	8	16%
		10-19 хүн	5	10%
		20-29 хүн	3	6%
		30-39 хүн	2	4%
		40-49 хүн	1	2%
		50-99 хүн	1	2%
		100-гаас дээш хүн	4	8%
		Тодорхойгүй	2	4%

Судалгаанаас харахад монголчууд зарга мэдүүлэхдээ тэр үеийнхээ хууль цааз, зарлиг тушаалд нийцүүлэн заргын бичгээ үйлдээд ганцаар, бүлгээр харилцан адилгүй тоотой бүлэг үүсгэн тэмцэлдэж байсан ба заргын эцсийн үр дүнд оролцогчдын тоо нь мэдээж чухал нөлөөтэй байжээ.

3. Зарга нь улс төрийн легитим оролцооны хэлбэр мөн.

Улс төрийн социологид оролцоог легитим ба легитим бус гэж хоёр ангилдаг. Бид судалгааныхаа дүнгээс харахад Манжийн ноёрхлын үед заргалдагч монголчуудын дийлэнх олонх нь тухайн нийгэмд үйлчилж байгаа төр засгаас баталсан хууль дүрмийн хүрээнд өөрсдийн шаардлагыг тавьж зарга үүсгэж, гэм буруутай этгээдэд хууль ёсны хариуцлага хүлээлгэхийг оролддог байжээ. Өдгөө бидний үед уламжлан ирсэн Манжийн ноёрхлын хийгээд Олноо өргөгдсөн Монгол Улсын үеийн он цагийн хувьд харилцан ялгаатай заргын бичгүүдээс үзэхэд заргалдагчид тухайн төрөөс тогтоосон хууль дүрмийг чанад баримтлан заргалдаж, хаант төрөөс орон нутгийн ноёд түшмэдийн эрхийг хязгаарлах бодлоготой заргаа уялдуулан амжилт олох явдал түгээмэл байв. Үүний жишээ болгож дээш өргөсөн нэгэн заргын бичгийн агуулгыг авч үзье. Олноо өргөгдсөний 6 /1916/ онд Сэцэн хан аймгийн Илдэн вангийн хошууны ард Бадамсэдээс олон ардыг дарлан үлэмжхэн алба татварлав хэмээн харьяат хошууны түшмэд нартай заалдаж, Сэцэн хан аймгийн Чуулган дарга, жанжин нарт өргөхдөө:

“... урьд Чин улсын эрх баригчид манай Халх монголчуудыг албадан дарлаж хяхаж мөлжин зовоосны улмаас Вачирдара Богд гэгээнээ Хаан эзэн өргөмжилж, Эрдэнийн сууринд залж, Түмэн наст, төр нээж тэлсэн

⁸ Үндэсний Төв Архив, Фонд ' М13, Данс ' 1., - Фонд ' М78, Данс ' 1., -Фонд ' М58, Данс ' 1, 2., - Фонд ' М34, Данс ' 1, 2., *Ардын заргын бичиг /XVIII-XX зууны эхэн/,* Эмхэтгэж хэвлүүлсэн Ш. Нацагдорж, Ц. Насанбалжир, Хянан засварласан Д. Гонгор, Улаанбаатар, Шинжлэх Ухааны Академийн Хэвлэх Үйлдвэр, 1966, 244 тал., *Хувьсгалаас өмнөх Монгол дахь газрын харилцаа /Архивын материалын эмхтгэл/,* Эмхтгэсэн Цэ. Шархүү, Редактор Ш. Нацагдорж, Улаанбаатар, Улсын Хэвлэлийн Газар, 1975, 252 тал.

их хишигт баярлалдан сүслэж, бүгдээр төв шудрагыг гол болгон төвшин журмыг мөрдөн дагаж бурхан шашнаа өргөн хүндлэж ер айх сочих татах түлхэхийн зовлонг өчүүхэн шийхин үзсэнгүй, амар жаргаланг эдлэсээр атал гагцхүү тус хошууны туслагч Ламжав, мэирэн Намжилдорж нарын ийнхүү олны санааг хувьсган зовоон чирэгдүүлэхээр үл барам харъяат хошуу цагийн түгшүүрт ойн сарниж чухам олны санаа сэтгэл хөдөлж завсардсан цагт ийм харгис төлөв зэхий түшмэд тушаалын бараа сүрээр дарлаж, Богд эзэн гэгээний нигүүлсэн өршөөх туйлын таалалд маш гажуудуулж нэгэн засаг хошууны нэрийг алдагдуулахад хүрэх төдийгүй харин байн байсаар улс төрд ямархан ноц будлиан эдүүлэхийг ер үгүй болгоход бэрх бөгөөд дорд өчүүхэн Бадамсэд би ийм учрыг нүд үзэж мэдсээр агаад хоосон зураг хөргийн мэт дур дуугүй дарагдуулж үнэхээрийн үл чадахын тулд үндэс бүхий журмыг хүсэн үнэн лавлалтай учрыг гаргаж тэд нарын урьд хожид хахуулилан авсан зүйлийг бүрнээ тодорхойлон ёроол уудлан мэдүүлбэл зохих авч чухам тодорхой мэдэх ба зөвхөн өөрийн хүү бие тулан дарлагдаж гардан өгсөн үзэж мэдсэнийг зүйл дараалан бичгийн сүүлд сийрүүлж үүнийг олдвол Сайд чуулганы дарга Дайчин жонон ван, Сайд жанжин Бишрэлт жүн ван таны гаднах, жасаадын түшмэд танаа өргөн мэдүүлээд гуйх нь элдэв учир эл гашуун цэнгэлийг нийгэмчлэн байцаан толилож, дээдэд болбол цааз сахилгыг гажуудуулж, журмыг балардуулан дордод болбол олны санааг хирдгэн хувьсгаж, сарниулахад хүртэл жигшүүртэй самуун явсан туслагч дөтгөөр зэрэг тайж Ламжав, мэирэн дөтгөөр зэрэг тайж Намжилдорж, мөн эдний адилаар санаа нийлж, харъяат захиргааны шудрага номхон түшмэл ардуудын хөрөнгийг хяхаж мөлжин зовоодог хүнд Арслан нарыг хэрхэн болгон гүйцэтгэн шийтгэж хорт дайсан мэт ховдог харгис түшмэлийн дарлах зовлонд эрсдэн олон түшмэл ардуудыг яахин авран өршөөж хүмүүжүүлэн тэнхрүүлж хойч өдрийг дагаж явах ариун суртал шулуун замыг олгуулахыг мөргөн гуйж мэдүүлэхээс гадна одоо туслагч Ламжав, мэирэн Намжилдорж нарыг тушаал бүхий цагт хошуу олны санаа нийлж уул нутаг үндсэнд бүрэн бүтэн тохинон хүмүүжин суухад үнэхээрийн бэрхтэй болсон ...”⁹

гэжээ. Ер нь монголчуудын зүйр цэцэн үгсийн баялаг санд заргын тэмцлийн шинж чанартай холбоотой олон чухал санаа бий. Тухайлбал, зарга үүсвэл өөрсдөө маргалдаж шийдэх бус харин түшмэлд очиж асуудлыг хууль дүрмийн дагуу шийдвэрлэхийг илэрхийлсэн үг нь “Замын уртыг тэмээ туулна, Заргын учрыг түшмэл олно” гэж хэлэх жишээтэй. Нэгэнт л зарга нь хууль дүрмийн дагуу шийдвэрлэгдэх ёстой юм бол баримт, гэрчийг чухалчлан үздэгийг “Баримтгүй хэрэг, Гэрчгүй зарга” гэсэн үгнээс харж болно. Мөн “Амьд хүний гэрч болохоор, Үхсэн хүний дэр бол” гэсэн нь заргад гэрчээр орох нь аль нэг хүнийг буруутган яллахад хүргэх ихээхэн хариуцлагатай ажил гэдгийг сануулсан үг мөн. Учир нь ямар ч заргад талууд ялалтыг өөрсдөө авахын тулд бие биенээ үндэсгүй гүтгэх явдал гардаг байсныг “Гүжиргүй зарга байдаггүй, Гүзээгүй

⁹ Ардын заргын бичиг /XVIII-XX зууны эхэн/, Эмхэтгэж хэвлүүлсэн Ш. Нацагдорж, Ц. Насанбалжир, Хянан засварласан Д. Гонгор, Улаанбаатар, Шинжлэх Ухааны Академийн Хэвлэх Үйлдвэр, 1966, 131-132-р тал.

гэдэс байдаггүй” гэж илэрхийлжээ. Тийм учраас “Заргыг шүүхэд хэцүү, Завхралыг засахад бэрх” гэж хэлэлцдэг байв.

4. Заргалдах нь “мэргэжилтнүүдийн” ажил мөн.

Жирийн иргэд эрх ашиг нь ноцтой зөрчигдөх үед өөрсдийгөө хамгаалахын тулд сонирхлын бүлэг үүсгэж тэмцэл өрнүүлж байв. Тиймээс заргын тэмцлийн явцад хэл ам сайтай, нарийн овсгоо сүүхээтэй, бичиг үсэг, хууль цааз гадарладаг хүмүүс ялгарч заргач хэмээн нэрлэдэг албан бус лидерийг төрүүлдэг байжээ. Нэгдүгээрт шууд эрх ашиг нь хохирсон хүмүүсээс заргач төрдөг, хоёрдугаарт өмнө нь олон удаа зарга хийж ялалт байгуулж байсан хүн өмнөөс заргалдах гэсэн хоёр үндсэн хэлбэрээр заргач ажилладаг байсан бололтой юм. Хоёрдугаар хэлбэрийн хувьд заргач нь тухайн бүлгийнхээ эрх ашгийг хамгаалахын тулд хүсэлтээр нь ажилладаг, мөн аж ахуйн хувьд ч гэсэн тэднээс ашиг орлого олдог, мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг хүмүүс Манжийн ноёрхол ба түүний дараа үеийн Монголд ч байжээ. Тухайн үед зарга тэмцлийн явцад бичиг үсэг, хууль цааз гадарладаг хүмүүс ялгарч заргач хэмээх албан бус хэмжээтэй болж ирсэн байна. Ийм хүмүүсийг иргэд ихэд хүндэтгэн юм асууж лавлах цаашилбал шаардлагатай тохиолдолд зөвлөгөө авдаг байжээ. Үүнийг харуулах нэгэн жишээг дурдаж болно.

“Цэцэгнуурын дугуйлангийнхан” гэж түүхэнд алдаршсан ардын эрх чөлөөний хөдөлгөөний толгойлогч Ард Аюуш 1912 онд арваадхан настай явсан намайг үзээд энэ хүүг баруун зүүнээ эс мэдэх “дөр хамагч” үгүй болхи толхи амьтан бүү болгоорой. Уг нь эрх хүн юм байна. Төр түмэндээ хүчин зүтгэх ээлж заавал ирнэ. Тэр цагт нь наад зах нь бичиг ном төсөөлсөн байвал алс хэтийнх нь амьдрал явдалд өлзийтэй болно гэж манайханд захиж хэлсэн¹⁰

гэснээс харж болохоор байна. Цаашид энэ асуудлыг тусгайлан түүх-улс төрийн социологийн тодорхой онолын үүднээс судлах шаардлагатай байгаа юм.

XVIII-XX зууны эхэн үед холбогдох дээш өргөсөн заргын бичгүүдэд бичлэгийн тогтсон хэлбэр байгааг хэлэх хэрэгтэй. Тэрчлэн дурдан буй үеийн заргын бичгийг амжилт олсон ба олоогүй гэсэн хоёр ангилалд хуваан үзэж учир шалтгааныг зөвхөн сурвалж, түүх-социологийн талаас гадна хууль цаазны шинжлэх ухааны талаас анхаарч судалбал нэн сонирхолтой байх болов уу. Ер нь заргыг хууль цаазын талаас нэлээд эрдэмтэд судалгааныхаа бүтээлд шууд болон дам байдлаар хөндсөн байдгийг тэмдэглэх хэрэгтэй.¹¹

5. Адгийн зарга арав хоногтой.

Манжийн ноёрхлын үеийн Монголын хууль цаазын бичгүүдээс үзэхүл тэр үеийн заргын тэмцлийг шийдвэрлэж байсан байдал нь жирийн ардуудад туйлын хүнд тусч

¹⁰ Ц.Даваажав. Монгол ардын журамт цэргийн дуртгалууд, Эмхэтгэж хэвлүүлсэн С.Уртнасан, Г.Цэрэндорж, хянан засварласан Ш.Нацагдорж. 1985, 5-7-р тал.

¹¹ Ш.Нацагдорж, Б.Содовсүрэн, С.Жалан-Аажав, Б.Баярсайхан, М.Хагихараны цуврал бүтээлүүдийг дурдаж болно. 1966, 131-132-р тал.

байсан бөгөөд олон өдөр сараар сунжирч дээш шат ахин зарга тэмцэл хийх нь тэдэнд тун их хохиролтой байжээ. “*Адгийн зарга арав хоног*” гэсэн үг нь үүний сонгодог илэрхийлэл бөгөөд үүний цаана төрийн хүнд суртал түүхэн аль ч үед оршин байдаг гэсэн санааг илэрхийлдэг. Тиймээс заргалдах гэж байгаа хүнийг туйлбартай, зоригтой, тэвчээртэй байхыг сургадаг байжээ. Ер нь халхын олон хошуудын он цагийн хувьд харилцан адилгүй, зарга бичгүүдийг судалж үзэхэд тухайн зарга тэмцэл эцэстээ хэрхэн шийдэгдсэн нь ихэвчлэн тодорхой бус байдаг нь ч нэгийг хэлж байна.

6. Зарга олон шат дамжлага дамжиж байв.

Өмнө өгүүлсэнчлэн Манжийн ноёрхлын үеийн Монголын хууль цаазын бичгүүдээс үзвэл тэр үеийн заргын тэмцлийг шийдвэрлэж байсан байдал нь жирийн ардад туйлын хүнд тусч байсан бөгөөд олон өдөр сараар сунжирч дээш шат ахин зарга тэмцэл хийх нь тухайн хүнд тун их хохиролтой байсан. “*Хөлөө хүрэх газар явж, Хэлээ хүрэх газар заргалдах*” гэдэг үг иргэдийн заргын ихэнх тохиолдолд шударга бусаар шүүдэг, тиймээс зарга үргэлжлэн засаг захиргааны бүх шат дамжлагыг дамждаг, тэр ч байтугай Манжийн хааны сонорт ч хүрэх тохиолдол гарсан. Аль ч тохиолдолд зарга хийгчид нь ижил асуудлаар хохирч гомдсон нөхөдтэйгээ санаа нийлж зохион байгуулалттай үгсэж хамтарвал амжилт олох нь илүүтэй байв.

7. Ноёдтой заргалдсан иргэд ихэнхдээ хохирч байв.

Ноёдтой заргалдаж байгаа хүмүүс нь заргын явцад өөрт ирэх бодит эрсдэл хохирлыг хүлээхээр эрс шийдвэрлэсэн хүмүүс байдаг. Тиймээс “*Задгай хүүхний хурим зүдрүү, Заргатай хүний царай зүдрүү*” гэж тодорхойлжээ. Ихэнх тохиолдолд заргаа авсан ч, аль эсвэл алдсан ч дараа нь тухайн нутаг хошуундаа амьдрах аргагүй болж, өөр хошуунд амьдрах, эс авбал хошуу хэсэж цагаачлах зэргээр амьдрал нь тун хүнд болдог байв. Үүнийг илэрхийлж “*Нохойд зусаргүй, Ноёнд нүүргүй болох*” гэж хэлж байжээ. Заргын тэмцлийн холбоотой зүйр цэцэн үгсээс шүүрдэн үзэхэд ерөөс зарга тэмцэл хийснээр эцсийн үр дагавар нь жирийн ардуудын хувьд хүнд байдалтай төгсдөг гэдэг үзэл санаа хүчтэй илэрдэг. “*Ноёнттой заргалдвал толгойгүй*” гэсэн үг нь үүнийг нотлох бөгөөд цаагуураа тухайн үеийн зарга тэмцлийг шийдвэрлэж байсан институтыг шүүмжлэн харуулжээ. Дээр дурьдсан зүйр үгнээс гадна сайтар шүүрдэн үзвэл заргатай шууд холбоотой биш боловч жирийн иргэдээс төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтнууд, ноёд язгууртнуудын талаарх санал сэтгэгдлийг тодорхой хэмжээнд харуулах зүйр үгс маш их байна.

Бид өмнөх өгүүлэлдээ, зарга тэмцэл нь зөвхөн “*ардын зарга*” байгаагүй, нийгмийн бүхий давхраа зарга тэмцлийг өргөн ашигладаг байсан тухай цухас дурдсан. Бид цаашид энэ тухай дэлгэрэнгүй өгүүлэл тэрлэхээр төлөвлөж байгаа болно. Ямар боловч эх сурвалж, судалгааны баримт сэлтийг нягтлан боловсруулж үзэхэд зарга нь хамрах цар хүрээ өргөн, нийгмийн бүхий л давхрааны хувьд тэмцлийн нэн түгээмэл хэлбэр байсныг батлан харуулж байна. Эцэст өгүүлэхэд, монголчуудын зүйр, цэцэн үгсийн арвин баялаг сангаас зарга тэмцлийн талаарх уламжлалт сэтгэлгээг гүнзгийрүүлэн судалж үзэх нь чухал юм.

Ном зүй

Дулам, С., "Монгол төрийн цагаан, хар туг-сүлдийн тахилга, бэлгэдэл",
Тамир, Ч., (2003). «Ардын зарга нь монголчуудын улс төрийн оролцооны уламжлалт хэлбэр мөн» //Түүх ' 2, МУИС-ийн Эрдэм шинуилгээний сэтгүүл.
Тамир, Ч., Төрдалай, Р., "Монгол заргын бичиг: Судалгааны арга зүй, аргачлалын асуудал", МУИС. Монгол Судлалын Төв, *Acta Mongolica* (Dedicated to the 100th Birthday of professor Yöngsiyebü Vyambyin Rinchen (1905-1977)), Улаанбаатар, 5(2005), 235-240-р тал.
Монгол зүйр цэцэн үгийн гурван мянган дээж, Эмхэтгэн найруулсан Д. Заяабаатар, Хянан засварласан Ш. Чоймаа, Улаанбаатар, 1999, 175 тал.

ABSTRACT

The article about the Mongolians petition. This study analyzed content of proverb about petition. The study illustrated in the content analyses, based historical origins of petition in traditional Mongolian society. The petition as form (legitimize) political participation of Mongolian Life.